



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**“Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн
2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг
шинэчлэн батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Зам хариуцагч компаниудын хариуцан ажиллах авто замын жагсаалт шинэчлэн батлах тухай” А/3 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталсантай холбогдуулан 2022 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Д.Болдбаатар)-д даалгасугай.

4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны “Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай” 660 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
 0... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ТӨВ АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		2022 оны Төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	ХБГ		Хувиар (2022төл/2021төл/)	Дүнгээр (2022төл-2021төл)
	<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</i>							
1	а/ Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	1,842,311.75	1,539,466.90	1,325,181.38	1,836,987.88	119.33	297,520.98
	б/ Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	1,162,622.90	350,000.00	526,641.25	800,192.23	228.63	450,192.23
	в/ Бусад орлого	мян.төг	18,946.40	13,063.60	24,600.00	24,600.00	188.31	11,536.40
2	Нийт орлого	мян.төг	3,023,881.05	1,902,530.50	1,876,422.63	2,661,780.11	139.91	759,249.61
3	Нийт зардал	мян.төг	3,014,245.94	1,889,032.00	1,838,802.10	2,620,264.66	138.71	731,232.66
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	177,236.32	246,387.00	231,794.11	304,904.01	123.75	58,517.01
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	9,635.11	13,498.50	37,620.53	41,515.45	307.56	28,016.95
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	8,671.60	12,148.70	35,118.48	37,363.90	307.55	25,215.20
6	Төсвийн төлбөрийн дүн	мян.төг	393,705.94	311,825.30	394,255.61	456,213.75	146.30	144,388.45
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	1,770.00	1,822.30	867.20	17,559.20	963.57	15,736.90
8	Нийт ажилчдын тоо	хүн	36.00	44.00	41.00	61.00	138.64	17.00
9	Нийт цалингийн сан	мян.төг	555,069.27	580,449.20	541,266.26	835,024.53	143.86	254,575.33
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,284.88	1,099.30	1,100.13	1,140.74	103.77	41.44
11	Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.00	0.99	0.98	0.98	99.14	(0.01)
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	4,639.40	80,000.00	-	157,177.80	196.47	77,177.80
	Нийт авлага	мян.төг	13,273.16	482,790.70	6,879.00	150,450.10	31.16	(332,340.60)
13	Үүнээс: Найдваргүй авлага	мян.төг	-	-	-	-	-	-
	Нийт өглөг	мян.төг	451,951.81	304,807.40	164,793.37	240,797.85	79.00	(64,009.55)
14	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	451,951.81	304,807.40	-	240,797.85	79.00	(64,009.55)
	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	-	-	-	-	-	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“ТӨВ АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
1	Замын индүү 5-7тн	Ш	1	85,000.0	85,000.0
2	Автокран 5тн	Ш	1	26,000.0	26,000.0
3	Үйлчилгээний машин	Ш	1	25,000.0	25,000.0
4	Ширээ	Ш	4	1,669.8	6,679.2
5	Сандал	Ш	5	419.9	2,099.5
6	Компьютер	Ш	4	2,699.8	10,799.2
7	Компьютерийн дэлгэц	Ш	1	1,599.9	1,599.9
	НИЙТ ДҮН				157,177.8 Нэг зуун тавин долоон сая нэг зуун далан долоон мянга найман зуу